



Орон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс

авсан 2024 оны 06 сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс



Дүгнэлт: Орхон аймаг Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 82 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 31 иргэн буюу 37.8% эмэгтэй, 51 иргэн буюу 62.2% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-29 насны 8 иргэн буюу 9.8% , 30-39 насны 56 иргэн буюу 68.3% ,40-49 насны 11 иргэн буюу 13.4% , 50-59 насны 7 иргэн буюу 8.5%, 50-59 аас дээш насны 7 иргэн буюу 8.5% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 82 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 7 иргэн буюу 8.5%, тэтгэмж 18 иргэн буюу 22.0%, сайн дурын даатгал 29 иргэн буюу 35.4%, нийгмийн даатгалын шимтгэл 5 иргэн буюу 6.1%, зөвлөгөө мэдээлэл 13 иргэн буюу 15.9%, бусад 10 иргэн буюу 12.2% тус бүр байна.


Хүснэгт1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар

		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын байгууллага үйлчилгээ шуурхай, хялбар байсан уу%	Маш сайн	20	24.4%
	Сайн	59	72.0%
	Дунд	3	3.7%
	Муу	-	
	Маш муу	-	
Нийт үр дүн		172	100%




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 20 даатгуулагч маш сайн үнэлгээг өгсөн (24.4%), сайн үнэлгээг 59 даатгуулагч буюу (72%), дунд үнэлгээг 3 даатгуулагч (3.7%), муу, маш үнэлгээг өгөөгүй байна.

Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 82 иргэн буюу (100%), “Үгүй” гэсэн үнэлгээг сонгоогүй байна.


Зураг 3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 80 иргэн буюу (97.6%) сэтгэл дундуур 2 иргэн (2.4%) тус бүр өгсөн байна.




Зураг4:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа ..\



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 82 иргэдийн “Тийм” үнэлгээг 6 иргэн буюу (7.3%), “Үгүй” үнэлгээг 70 иргэн буюу (85.4%), Мэдэхгүй үнэлгээг 6 иргэн буюу (7.3%) тус бүр үнэлсэн байна.


График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 82 иргэдийн “Тийм” үнэлгээг иргэн өгөөгүй байна. Үгүй” үнэлгээг 82 иргэн буюу (100%) тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна .



График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив тусалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон “Үгүй” үнэлгээг 82 иргэн буюу (100%) тус бүр үнэлсэн байна.

Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?



- ✓ Маш их баярлалаа
- ✓ Маш их баярлалаа
- ✓ Түргэн шуурхай ажилласанд баярлалаа
- ✓ Шударга шуурхай байсанд баярлалаа
- ✓ Маш их баярлалаа
- ✓ Маш их баярлалаа

Судалгааны нэгтгэл хийсэн:/Ө.Нэргүй /